



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 1/64

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгслийн дуудлагын
худалдааг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29, 31 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 6.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/263 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны 03 дугаар сарын
05 өдрийн 0/64 тоот тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Төмөрбаатар Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

М.Мандах Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга

П.Батжаргал Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төвийн дарга

Б.Эрдэнэмөнх Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

О.Уранчимэг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Батхуяг Захиргаа санхүүгийн хэлтсийн хэвлэл, мэдээлэл хариуцсан ажилтан

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б.Батаа Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн